



## БАЙГАЛЬ ОРЧНЫ ХОХИРЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХОЛИМОГ ЗАГВАР: ИРГЭНЛЭГ БА НИЙТЛЭГ ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛЫГ ХОСЛУУЛСАН МАТЕРИАЛЛАГ ЭРХ ЗҮЙН ХАНДЛАГА

### A MIXED PRIVATE-LAW MODEL FOR ADDRESSING ENVIRONMENTAL DAMAGE: A SUBSTANTIVE LEGAL APPROACH INTEGRATING CIVIL-LAW AND COMMON-LAW TRADITIONS

Б.Алтансоёмбо<sup>1</sup>

Shihihutug University, E-mail: altansoyombo@shihihutug.edu.mn

#### ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

##### **Түлхүүр үгс:**

байгаль орчны хохирол, гэм хор, деликт, торт, экологийн хохирол, холимог хувийн эрх зүй, нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл.

##### **Keywords:**

environmental harm, delict, tort, ecological damage, private-law model, public-interest standing.

##### **Нийтлэлийн түүх:**

Хүлээн авсан: 2025, 10 сар  
Шинэчилсэн: 2025, 10 сар  
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

##### **Article history:**

Received Oct, 2025  
Revised Oct, 2025  
Accepted Oct, 2025

#### ХУРААНГУЙ

Энэхүү нийтлэл нь байгаль орчинд учирсан хохирлыг үр нөлөөтэй барагдуулахад хувийн эрх зүйн нөөц, боломжийг үр дүнтэй ашиглахын тулд харьцуулсан эрх зүйн шинжилгээ хийж, холимог тогтолцоо бүрдүүлэх онол-арга зүйн үндэслэл, шаардлагыг тодорхойлох зорилготой. Иргэнлэг эрх зүйн уламжлалд хамаарах деликтийн тогтолцоо нь хамгаалагдсан эрх, шалтгаант холбоо, гэм бурууг тодорхойлох нарийн шалгууртай боловч байгаль орчны тархмал, олон хүчин зүйлд суурилсан хохирлыг бүрэн хамарч чаддаггүй. Харин нийтлэг эрх зүйн тортын тогтолцоо нь уян хатан боловч өндөр зардал, нотолгооны төвөгтэй шаардлага болон тогтворгүй прецедентэд тулгуурлах сул талтай.

Харьцуулсан эрх зүйн судалгаанд Францад “цэвэр экологийн хохирол”-ыг бие даасан ангиллаар хүлээн зөвшөөрсөн, Германд байгаль орчныг эрх зүйн хувьд хамгаалагдах субъект байдлаар авч үзэх хандлага төлөвшиж буй зэрэг шинэтгэлийн чиглэл тодорхой харагдаж байна. Эдгээр туршилага нь байгаль орчны эрхийг зөвхөн өмчийн хохиролтой адилтгах бус, экосистемийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах эрх зүйн үнэт зүйл болгон хөгжүүлэх шаардлагыг нотолж байна.

Монгол Улсын хувьд Иргэний хуулийн 497.1-д заасан “бусдын эрх” гэдэг ойлголтыг экологийн эрх болон нийтийн өмчийн эрхтэй уялдуулан тайлбарлах боломж бий. Ингэснээр экологийн хохирлын тусгай ангилал тогтоох, гэм буруугүй болон хамтарсан харьцуулага хүлээлгэх, мөн иргэний нийгмийн байгууллагад хязгаартай хэмжээнд нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах эрх олгох зэрэг хувийн эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэх боломж нээгдэнэ.

Ийм хандлага нь байгаль орчны хохирлыг зөвхөн захиргааны болон нийтийн эрх зүйн хүрээнд шийдвэрлэх бус, хувийн эрх

<sup>1</sup>Шихихутуг их сургууль, Хувийн эрх зүйн тэнхим Магистрант

зүйн нөхөн төлбөр, сэргээн хамгаалах механизмуудтай уялдуулсан холимог загварыг бий болгох замаар Үндсэн хуулиар баталгаажсан экологийн эрхийг бодитойгоор хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ.

#### **Abstract**

*This article aims to identify the theoretical and methodological foundations and the necessity for establishing a mixed regulatory model by conducting a comparative legal analysis to determine how the resources and capacities of private law may be effectively utilized in addressing environmental damage. Comparative analysis of legal developments in Germany, France, the United Kingdom, the United States and India demonstrates that environmental harm characterised by diffuse impact, multiple causal sources, and a predominant public-interest dimension—cannot be adequately resolved through traditional delict or tort rules alone.*

*Recent developments, such as France’s recognition of pure ecological damage and emerging German case law conceptualising nature as a rights-bearing entity, show a clear shift toward expanding private-law protection of ecological interests. Building on these tendencies, the article advances the view that the phrase “rights of others” in Article 497.1 of the Mongolian Civil Code may validly be interpreted to include environmental rights and collective interests in public resources.*

*Such an interpretation would permit the introduction of strict and joint liability for ecological harm, recognition of distinct categories of environmental damage, and a limited form of public-interest standing for civil-society organisations. Incorporating these mechanisms would help establish a coherent mixed model that links private-law remedies with public regulatory measures and thereby strengthens judicial protection of constitutionally guaranteed environmental rights.*

Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



## **1. Танилцуулга**

Эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрэхийн тулд байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах болон нөхөн сэргээх асуудал өнөө үед урьд урьдахаасаа илүү хурцаар тавигдах болсон байна. Үүнтэй холбоотойгоор байгаль орчинд учирсан хохирлыг хэрхэн барагдуулах, эрх зүйн ямар тогтолцоогоор үр нөлөөтэй зохицуулах тухай асуудал нь салбар бүрийн эрдэмтэн судлаачдын анхаарлыг татсан сонирхолтой, чухал сэдвийн нэг болжээ.

Гадаад, дотоодын судлаачдын бүтээл болон шүүхийн шийдвэрийн санд тулгуурлан харьцуулсан шинжилгээ хийхэд уламжлалт материаллаг эрх зүйн зохицуулалт нь байгаль орчны хохирлыг бүрэн шийдвэрлэх боломжийн хувьд тодорхой хязгаарлалтай байдаг нь манай хувийн эрх зүйд тулгамдсан асуудал юм.

Тухайлбал, байгаль орчны хохирлыг иргэнлэг эрх зүйн уламжлалын деликтийн онол, нийтлэг эрх зүйн тортын эрх зүйн үүсэл, үзэл сургаал, онолын хөгжлийн үүднээс, мөн олон улсын практик болон бусад улс орнуудын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлахад эдгээр тогтолцоо нь тус бүрдээ онол-сургаалын онцлог, давуу талтай боловч байгаль орчны хохирлын шинж чанарт бүрэн нийцэж чадахгүй, тодорхой эргэлзээ дагуулдаг.

Тэгвэл “Байгаль орчин” нь “эд хөрөнгө” мөн үү гэсэн асуултад хариулт хайх шаардлагтай. Учир нь байгаль орчинд учирсан хохиролын маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд [497.1, 510.1] гэсэн хосолсон хэрэглээ олонтоо тохиолдог.<sup>2</sup> Манай шүүхийн практикт байгаль орчны хохиролыг бусдын эд хөрөнгөд учирсан гэм хор гэж үзэн шийдэж байгаа нь судалгаагаар батлагдсан. Харин бусад улс орнуудын хувьд шаардах эрх болон үүсэх хариуцлага хоорондын холбоос ихээхэн маргаан дагуулсан асуудал байдаг. Монгол Улсын Иргэний хуулийн гэм хорын ерөнхий зохицуулалтад заасан хамгаалах эрхэд “Бусдын эрх” гэсэн томъёоллын агуулга бий. Үүнийг “нийтийн өмчийн эрх” болон “байгаль орчны эрх” хэмээх нийтийн шинжтэй үнэт зүйлсийг багтааж тайлбарлах боломжтой гэж үзвэл, байгаль орчинд учирсан хохирлыг одоогийн хууль тогтоомжийн хүрээнд хувийн эрх зүйн журмаар барагдуулах боломж нээлттэй байна. Гэвч иргэний эрх зүйн гэм хорын уламжлалт зохицуулалтад нийтийн эрх ашгийг хамгаалах зарчим ямар түвшинд тусгагдах ёстой, ингэхдээ хувийн эрхийн тогтолцооны суурь зарчимтай хэрхэн нийцэх, практикт хэрхэн хэрэгжүүлэх зэрэг асуудалд онолын судалгаа болон хууль тогтоомжийн нарийвчилсан шийдэл шаардлагатай.

Шүүхийн практикт ч энэ чиглэлээр гарч буй зарим хууль хэрэглээний зөрүүтэй байдал, нэг мөр биш байгаа нь эдгээр асуудлыг онолын түвшинд нэгтгэн боловсруулах, байгаль орчны хохирлыг хувийн эрх зүйд хариуцлага хүлээлгэх зохицуулалтын логик, суурь зарчмыг тодорхой болгох шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна. Нийтийн эрх ашгийг шүүхээр хамгаалах нь шударга ёсыг хангах чухал зорилт хэдий ч энэ нь хувийн эрхийн баталгааг сулруулах хэлбэрээр биш, харин хуульчлагдсан, тэнцвэртэй, урьдчилан тодорхойлогдсон механизмаар хэрэгжих ёстойг анхаарах нь зүйтэй.

Иймээс энэхүү нийтлэлд иргэнлэг болон нийтлэг эрх зүйн уламжлалыг харьцуулан судалж, байгаль орчны хохирлын онцлогт ямар материаллаг эрх зүйн хандлага илүү тохирох талаар онол-арга зүйн түвшний үндэслэлүүдийг авч үзнэ. Мөн Монгол Улсын хувийн эрх зүйн тогтолцоонд эдгээр зарчмыг хэрхэн уялдуулан хэрэглэх боломж, хэрэгцээг хэлэлцэж, зохицуулалтын талаархи өнөөгийн ойлголтыг баяжуулахад чиглэсэн санаануудыг дэвшүүлэх юм.

## 2. Арга зүй

Энэхүү судалгаа нь иргэнлэг, нийтлэг эрх зүйн онолуудыг харьцуулан шинжилж, байгаль орчны хохирлыг шийдвэрлэхэд тохиромжтой материаллаг эрх зүйн холимог загварыг тодорхойлох зорилготой.

## 3. Судалгааны үр дүн

Иргэнлэг эрх зүйн бүлийн деликтийн бүтцийн хязгаар:

---

<sup>2</sup> Г.Амаржаргалан, *Байгаль орчинд учирсан гэм хорыг арилгах зохицуулалт дахь хувийн эрх зүйн онолын тулгамдсан асуудал, 2023, Хүрээлэн буй орчин ба хүний эрх: Харьцуулсан судлал ОУЭШХ эмхтгэл, х.38-44*

“Деликт” хэмээх нэр томъёо нь *delictum* буюу “хууль бус, эрх зөрчсөн үйлдэл”-ээс үүсэх үүргийг илэрхийлдэг гэж Гайус<sup>3</sup> тэмдэглэсэн байдаг. Деликт нь “хууль бус үйлдэл үйлдсэн этгээдийн хариуцлага” гэсэн утгыг агуулж, хувийн эрх зүй дэх иргэн хүний эрхийн хамгаалалтын анхны институт болж хөгжсөн бөгөөд өнөөгийн Ром–Герман буюу иргэнлэг эрх зүйн бүлийн орнуудад хэрэглэгдэж буй гэм хорын эрх зүйн суурь ойлголт болон уламжилжээ. Энэхүү уламжлал XIX–XX зууны Европын иргэний хуулиудад шингэж, Францын Иргэний хуулийн 1240, Германы Иргэний хуулийн §823 зэрэгт “тодорхой хамгаалагдсан эрхийг зөрчсөн тохиолдолд хариуцлага үүснэ” гэсэн зарчим мөрдөгдсөн хэвээр байна.

Иргэнлэг эрх зүйд деликтийн хариуцлага үүсэхийн тулд:

- хамгаалагдсан эрх зөрчигдөх,
- хохирол учрах,
- шалтгаант холбоо байх,
- гэм буруу тогтоогдох гэх мэт дөрвөн тулгуур элементийн систем<sup>4</sup> Европын эх газрын иргэнлэг эрх зүйд эртний Ромын үеэс уламжлан бүрэлдэн тогтсон (Zimmermann, 1996).

Харин байгаль орчны хохирол нь ихэвчлэн олон нийтийг хамарсан тархмал шинжтэй, хохиролын шалтгаан хэд хэдэн хүчин зүйлийн нөлөөлөлтэй байдаг тул буруутай этгээдийг тогтоох нь хүндрэлтэй, хохирол шууд хэмжигдэхгүй байх зэрэг онцлогтой учир уламжлалт деликтийн шалгуур нь бүрэн тодорхойлж чаддаггүй.

Тухайлбал Германд байгаль орчны хохирлыг хувийн эрх зүйн журмаар шийдвэрлэх оролдлого 1988 онд Хойд тэнгисийн далайн хавын эрхийг хамгаалах нэхэмжлэлээр<sup>5</sup> эхэлж, цаашлаад Элбэ голын бохирдлын маргаан<sup>6</sup>, ойн сүйрэл<sup>7</sup> болон агаарын бохирдлын асуудлуудаар үргэлжлэх явцад уламжлалт деликтийн тогтолцоонд хамгаалагдсан эрхийн хүрээ буюу шаардах эрх хэт нарийвчлалтай тогтоогдсон байдаг тул байгаль орчны хохирлыг гэм хорын эрх зүйн хамгаалах зүйл гэж хүлээн зөвшөөрөх боломж онол-практикийн хувьд хязгаарлагдмал байсаар ирснийг жишээ баримтаас харж болно.

<sup>3</sup> Гайус (*Gaius*; МЭ 130–180 орчим) нь Ромын нэрт хуульч байв. Түүний хувийн амьдрал, тухайлбал овог, гарал үүслийн талаар бараг мэдэгдээгүй бөгөөд *Gaius* (эсвэл *Caius*) нь зөвхөн түүний хувийн нэр (*praenomen*) байсан гэж үздэг. Түүний амьдралын он цагийг яг таг тогтоох боломжгүй боловч бүтээлүүдэд нь агуулагдсан хууль тогтоомжийн хугацааг үндэслэн МЭ 130–179 оны хооронд амьдарч байсан гэж таамагладаг. Гайус нас барсныхаа дараа эрх зүйн ухаанд өндөр нэр хүндтэй болж, Ромын эзэн хаан Теодосийс II (*Theodosius II*) түүнийг Папиниан (*Papinian*), Ульпиан (*Ulpian*), Модестин (*Modestinus*), Паулуc (*Paulus*) зэрэг нэрт хуульчдын хамтаар Хуулийн ишлэлийн хууль (*Law of Citations*)-д нэрлэж, шүүгчид эдгээр таван хуульчийн саналд тулгуурлан шийдвэр гаргах үүрэгтэй болсон юм. Ийнхүү Гайусын бүтээлүүд Ромын эрх зүйн гол эх сурвалжуудын нэг болсон. Гайусын бүтээлүүд Юстинианусын үед дахин эмхэтгэгдсэн бөгөөд *Corpus Juris Civilis*-ийн бүрэлдэхүүнд орсон *Digest* болон *Institutiones* бүтээлүүдийн бүтэц, арга зүй нь Гайусын *Institutiones*-ээс шууд хуулбарласан бөгөөд олон хэсэг үгчилсэн байдлаар давтагддаг. Гайусын бүтээл нь бараг гурван зууны турш Ромын эрх зүйн оюутнуудын үндсэн сурах бичиг болж хэрэглэгдсэн гэж үздэг.

<sup>4</sup> Дөрвөн тулгуур элемент гэдэг нь: *injuria* — эрх зөрчсөн, хууль бус байдал, *damnum* — хохирол, *causa* — учир шалтгааны холбоо, *culpa/dolus* — гэм буруу

<sup>5</sup> *Germany court case: seals in the North Sea* (1988)

<sup>6</sup> *European Commission v. Federal Republic of Germany (C-142/16)* (European Court of Justice, Second Chamber) (26 April 2017) - ELAW: Environmental Law Alliance Worldwide

<sup>7</sup> *The History of the German Forest - The Germany Magazine of the Goethe-Institut - #DeutschlandNoFilter - Goethe-Institut*

Гэвч экологийн ноцтой өөрчлөлт, бусад улс орнуудын эрх зүйн хөгжлийн нөлөө, нийгмийн сэтгэлгээ, үзэл санааны хувьсал зэргээс үүдэн Германы шүүхийн практикт шинэ хандлага бүрэлдэж эхэлсэн бөгөөд түүний тод илрэл нь Германы Эрфурт хотын Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн<sup>8</sup> “дизель скандал”-тай холбоотой асуудлыг шийдсэн 2024 оны шийдвэр болоод байгаа юм. Тус шүүх анх удаа байгаль орчныг **“өөрийн эрхтэй субъект”** гэж үзсэн ба эрх зүйн хамгаалалттай үнэт зүйл гэж үзэх боломжтой талаар шийдвэрт тусгасан нь экологийн хохирлыг деликтийн эрх зүйн орчин үеийн тайлбар зүйд багтаах боломж нээгдэж буйг харуулсан.

Ингэснээр уламжлалт деликтийн эрх зүйн бүтэц байгаль орчны хохиролд бүрэн нийцэхгүй гэсэн өмнөх байр суурь аажмаар өөрчлөгдөж, Германы хувийн эрх зүйд **“байгаль орчны эрх”**-ийг тусгайлан хүлээн зөвшөөрөх, эсвэл хамгаалалттай эрх зүйн үнэт зүйл гэж үзэх материаллаг эрх зүйн шинэчлэлийн чиг хандлага бий болох бодит хүлээлтийг үүсгээд байна.

Харин Францын деликт эрх зүй байгаль орчны хохиролтой холбоотой шинэ сорилтуудад хариу өгөхийн тулд хувьсан хөгжиж, “цэвэр экологийн хохирол” (*préjudice écologique pur*) гэх эрх зүйн шинэ ойлголтыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд өмнө дурдсанчлан Германы Эрфурт хотын Иргэний хэргийн шүүхийн шүүгч Мартин Боровскийн шүүхийн шийдвэр иш татан хэрэглэгдэх хэмжээнд шинэчлэлийг түүчээлсээр байна. Францын хувийн эрх зүйн хэрэглээг Германтай харьцуулахад илүү уян хатан бөгөөд шүүхийн тайлбар, хууль хэрэглээний идэвхтэй арга зүйн тайлбараар байгаль орчныг хамгаалах хандлагаа өргөтгөдөг. Энэ нь байгаль орчинд учирсан хохирлыг экосистем, амьд байгалийн төрөл зүйлд учирсан хохирол гэж тусгаарлан авч үздэг бөгөөд хувь хүний өмч, эд хөрөнгөд шууд хамааралгүй нөхцөлд ч гэм хорын хариуцлага үүсэх боломжийг бий болгосон юм.

Гэсэн хэдий ч Германд байгаль орчинд учирсан хохирлыг гэм хорын эрх зүйгээр бүрэн хэмжээнд шийдвэрлэх боломжтой эсэх нь онол-практикийн хувьд эргэлзээтэй хэвээр байгаа бол, Францын хувийн эрх зүйд деликтийн хэм хэмжээг захиргааны хариуцлагын арга хэмжээтэй хослуулан хэрэгжүүлэх замаар байгаль орчныг хамгаалах зохицуулалтыг шинэчлэх хандлага давамгайлах болсон нь харьцуулсан судалгаагаар ажиглагдаж байна.

“Деликт” нь хувийн эрх зүйн маргаан шийдвэрлэхэд хамгийн боловсронгуй онол-сургаалын суурь үзэл баримтлалд тооцогддог бөгөөд Монгол Улсад ч энэхүү ойлголтыг Иргэний хуульд “зөрчигдсөн эрхийг сэргээх зарчим” (Иргэний хуулийн 1.2, 9.4.4), гэм хор арилгах нийтлэг үндэслэл (Иргэний хуулийн 497.1, 228) болгон тусгаж өгсөн байна.

Гэвч асуудлын төв нь хувийн эрхийг хөндөөгүй нийтийн эрх — ялангуяа “байгаль орчны эрх” хөндөгдөж буй нөхцөлд деликтийн уламжлалт дүрмийг шууд хэрэглэх нь оновчтой эсэхэд эргэлзээ бий. Иргэний эрх зүйн уламжлал бүхий улс

<sup>8</sup> *Landgericht Erfurt Эрфурт хотын давж заалдах шатны шүүх. ХБНГУ-ын шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжын дагуу 5000 еврогоос дээш үнийн дүнтэй эсвэл нарийн төвөгтэй хэрэг маргааныг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг байна. Энэ нь ердийн шүүхийн бүтэцэд хамаардаг бөгөөд үүний өмнө Amtsgericht орон нутгын шүүх буюу анхан шатны шүүх эрүү, иргэн, гэр бүлийн жижиг маргааныг анхан шатны журмаар шийддэг байна.*

орнууд (Герман, Франц зэрэг) ийм нөхцөлд уламжлалт деликтийн хүрээ хангалтгүй байгааг онолын түвшинд хөндөж, нийтийн эрхийн шинжтэй байгаль орчны хохирлыг хэрхэн үнэлж, хамгаалах талаар шинэ үзэл баримтлалд тулгуурласан шүүхийн шинэ практик боловсорч эхэлж буйг бид анхааралтай судлах ёстой.

Өөрөөр хэлбэл, харьцуулсан эрх зүйн үүднээс ижил эрх зүйн уламжлалт хамаарах улс орнуудад “нийтийн эрх”, “байгаль орчны эрх” зөрчигдөх үед уламжлалт деликтийн хүрээг давсан материаллаг эрх зүйн шинэ хандлага төлөвшиж эхэлж байгаа нь Монгол Улсын хувьд мөн адил эрх зүйн зохицуулалтаа дахин шинээр эргэцүүлж, нийтийн эрхийн шинжтэй байгаль орчны хохиролд тохирох зохицуулалтын шийдлийг боловсруулах шаардлагатайг харуулж байна.

*Нийтлэг эрх зүйн бүл дэх тортын хариуцлагын онол ба шинэчлэлийн уян хатан байдал:*

“Торт” (tort) хэмээх нэр томъёо нь латин хэлний “*tortum* - мухардал, гэмтэл” болон хуучин франц хэлний “*tort*- алдаа, буруу үйлдэл” гэсэн үгнээс гаралтай бөгөөд нийтлэг эрх зүйн<sup>9</sup> бүлд хамаарах улс орнуудын хувьд торт гэдэг нь гэрээний зөрчилд хамаарахгүй, хуулиар нөхөн төлүүлэх боломжтой иргэний буруутай үйлдэл юм (Pollock, 1895). Тортын онолын хөгжлийн онцлог нь Англи, Америкийн нийтлэг эрх зүйн тогтолцоонд шүүхийн прецедент болон Зөрчлийн хуулийн<sup>10</sup> хослон зохицуулах уян хатан шинжээр илэрдэг. Шүүхийн шийдвэр тодорхой төрлийн хохирлын ангиллыг тогтоож, ижил төстэй хэргүүдэд заавал дагаж мөрдөх жишиг үүсгэдэг нь тортын эрх зүйн суурь механизмаар тогтсон. Гэвч XIX–XX зуунд аж үйлдвэржилт хурдацтай хөгжиж, байгаль орчинд хохирол үзүүлэх шинэ төрлийн эрсдэл, бохирдол олширсноор уламжлалт прецедент дангаараа хүрэлцэхгүй болж, Зөрчлийн хууль буюу хуульчлагдсан тортын зохицуулалтууд Англи, АНУ-д бий болж эхэлсэн.

Энэ үеэс хатуу хариуцлага<sup>11</sup>, төвөг учруулах<sup>12</sup> болон хайхрамжгүй үйлдэл<sup>13</sup> зэрэг уламжлалт тортын зарчимуудыг агаар, ус, хөрсний бохирдол, нийтийн эрүүл мэндэд хохирол учрах, заналхийлэл зэрэг байгаль орчны хохиролд хэрэглэж эхэлсэн.

Нийтлэг эрх зүйн бүлийн улс орнуудын хувьд байгаль орчны хохирлыг шийдэхэд тулгардаг бэрхшээл нь нэхэмжлэгчийн шүүхэд хандах боломж, процессын хүртээмж, нотлох баримтын стандарт, шүүхийн институцийн чадавх, нийгмийн үнэт зүйл, эдийн засгийн хүчин зүйлтэй нягт уялдаатай, олон давхаргат хариуцлагын асуудал гэдгийг олон улсын туршлага тодорхой харуулдаг. Тухайлбал, АНУ-ын олон тойргийн

<sup>9</sup> *Common law*- Англи-Саксоны эрх зүйн систем ч гэдэг Англид үүсэж, улмаар АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд зэрэг Британийн эрх зүйн уламжлалтай орнуудад хөгжссөн эрх зүйн бүл бөгөөд дэлхийн гол хоёр эрх зүйн бүлийн нэгд тооцогддог. Энэ тогтолцооны онцлог нь **хууль тогтоомж (statute)**-оос гадна **шүүхийн шийдвэр (case law)** нь эрх зүйн эх сурвалжын хамгийн чухал хэсгийг бүрдүүлдэгт оршино.

<sup>10</sup> Зөрчлийн хууль (*statutory torts*) хууль тогтоох байгууллагаас батлан гаргасан хууль, тогтоомж зэргийг байгаль орчны хэрэгт өндөр түвшинд ашигладаг.

<sup>11</sup> *Strict liability* - хатуу хариуцлагын онол буюу хариуцагч нь гэм буруугүй байсан ч хохирол үүссэн бол хатуу хариуцлага хүлээх тогтолцоо нь байгаль орчны гэм хорын хариуцлагын гол зарчим болдог.

<sup>12</sup> *Nuisance* - төвөг учруулах төрөл нь хувь хүн болон олон нийтийн эрх ашгийг зөрчсөн тасралтгүй бохирдол, дуу чимээ, үнэр гэх мэт нөлөөлөлөөс үүссэн хохиролд хүлээлгэх хариуцлага.

<sup>13</sup> *Negligence* - хайхрамжгүй байдал нь аюултай, хортой үйл ажиллагаа явуулж буй этгээд урьдчилан сэргийлэх боломжтой хохирлыг үүсгэсэн тохиолдолд хүлээх хариуцлага.

нэгдсэн хэрэг хянан шийдвэрлэх журам<sup>14</sup> нь олон хохирогчтой хэргийг нэг мөр шийдвэрлэх боломж олгодог бол Энэтхэгийн Дээд шүүх нийтийн ашиг сонирхлын төлөөх нэхэмжлэл<sup>15</sup>-ийг өргөн хэрэглэж, гуравдагч этгээд болон ТББ-д оролцох эрх олгосноор шүүхийн оролцоог нийгмийн ашиг сонирхлын талд идэвхжүүлсэн байдаг.

АНУ-ын хувьд Зөрчлийн хууль болон масс тортын механизм уян хатан, олон төрлийн нотолгоонд тулгуурласан үр дүнтэй системийг бүрдүүлсэн ч зардал өндөр, шинжээч төвтэй процесс давамгайлдаг. Харин Энэтхэгт тортын онолыг Үндсэн хуулийн эрхтэй холбож хөгжүүлсэн онцлогтой бөгөөд үнэмлэхүй хатуу хариуцлагын онол<sup>16</sup>, гүн халаасны онол<sup>17</sup>, нийтийн ашиг сонирхлын төлөөх нэхэмжлэл<sup>18</sup> зэрэг шинэ арга замуудыг ашиглан өөрийн онцлог бүхий эрх зүйн шийдлийг гаргаж байна.

#### Дүгнэлт

Нийтлэлд дурьдсан улс орнуудын туршлага, харьцуулсан судалгаа нь зөвхөн онол төдий биш, харин манай улсад байгаль орчны гэм хорын хариуцлагын тогтолцоог бодитоор шинэчлэхэд чухал сургамж өгөх ашиг тустай гэж үзсэн. Тортын эрх зүй нь уламжлал ёсоор хувийн эрхийн хүрээнд хохирлыг нөхөн төлүүлэх механизм байсан боловч байгаль орчны хохиролтой холбоотой асуудлыг шийдвэрлэх арга зам нь уламжлалт зохицуулалтын хүрээг давж, нийгмийн хариуцлага, экологийн тогтвортой байдал, нийтийн эрхийн хамгаалалт зэрэг өргөн хүрээг хамарсан илүү иж бүрэн хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх болжээ.

Иймд олон улсын эдгээр туршлагыг харьцуулж үзэхэд Монгол Улсад байгаль орчны хохирлыг шийдвэрлэхэд Их Британиас нотлох баримтын илүү тодорхой стандарт, Энэтхэгээс нийтийн ашиг сонирхлын төлөөх нэхэмжлэл ба уян хатан, нийтийн эрхэд чиглэсэн хандлага, АНУ-аас олон хохирогчтой хэргийг нэгтгэн шийдвэрлэх процессын механизмыг холимог байдлаар ашиглах боломжтой гэж дүгнэж байна. Эдгээр нь Монгол Улсад байгаль орчны хохирлын хариуцлагын холимог тогтолцоог бүрдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулахуйц, онол-практикийн хувьд боломжит чиглэлүүд байж болох юм.

Байгаль орчны хохирлыг нөхөн төлүүлэх материаллаг эрх зүйн зохицуулалтын холимог загварын санал:

Судалгаанаас үзвэл байгаль орчны хохирлыг уламжлалт иргэнлэг ба нийтлэг эрх зүйн загваруудаар дангаар нь зохицуулах боломж хязгаарлагдмал тул Монгол Улсад материаллаг эрх зүйн холимог бүтцийг төлөвшүүлэх нэн тэргүүний хэрэгцээ шаардлага тулгарч байна. Тухайлбал:

#### 1. Иргэнлэг эрх зүйн давуу тал ба хязгаар

<sup>14</sup> Олон хохирогчтой (Mass torts) хэргүүдийг Олон тойргийн шүүхийн нэгдсэн хэрэг хянан шийдвэрлэлтийн журам (Multidistrict Litigation, MDL) журмаар нэгтгэж шийдвэрлэх чадвартай.

<sup>15</sup> Нийтийн ашиг сонирхлын төлөөх нэхэмжлэл (Public Interest Litigation PIL)-ийн замаар гуравдагч этгээд, ТББ байгаль орчны төлөө шүүхэд хандах боломжтой.

<sup>16</sup> Absolute liability – хатуу хариуцлагын онолын нэгэн хувилбар бөгөөд хохирол үүссэн байхад л хариуцлага оногдуулахад хангалттай гэж үздэг.

<sup>17</sup> Deep pocket theory Эдийн засгийн шинжлэх ухаанд санхүүгийн чадамжтай тал нь түрүүлж хохирлыг хариуцах зарчмыг байгаль орчиноос үүдэлтэй хохиролын нөхөн төлбөрт ашиглах Энэтхэгийн шийдэл.

<sup>18</sup> Нийтийн ашиг сонирхлын төлөөх нэхэмжлэл (Public Interest Litigation PIL)-ийн замаар гуравдагч этгээд, ТББ байгаль орчны төлөө шүүхэд хандах боломжтой.

Деликтийн хариуцлага нь хамгаалагдсан эрхийн хүрээ, шалтгаант холбоо, гэм буруу зэрэг тодорхой шалгууртай, тогтсон бүтэцтэй тул системчлэл сайтай боловч байгаль орчны тархмал, олон эх үүсвэртэй хохиролд уян хатан хариу өгөхөд хүндрэлтэй.


2. Нийтлэг эрх зүйн давуу тал ба хязгаар

Tort-ийн тогтолцоо нь прецедентын уян хатан хөгжлөөр шинэ төрлийн хохиролд зохицох чадвартай ч:

- шүүхийн практикт хэт тулгуурладаг;
- тогтвортой, нэг мөр материаллаг зарчмын хүрээ сул;
- хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангахад хүндрэлтэй.

Иргэний хуулийн 497.1-д “бусдын эрх” гэх ойлголтыг “байгаль орчны эрх” болон эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн агуулгатай уялдуулан өргөн тайлбарлах боломж бий. Ингэснээр:

- гэм буруугүй хариуцлага,
- хамтарсан болон бие даасан хариуцлага,
- экологийн хохирлын тусгай ангилал



зэрэг олон улсын хөгжлийн чиг хандлагыг Монголын хувийн эрх зүйд нэвтрүүлэх боломж бүрдэнэ. Энэ нь байгаль орчныг зөвхөн өмчийн хохирлоор хэмжих бус, экосистемийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах материаллаг эрх зүйн шинэ түвшний механизмыг бий болгоход чиглэнэ.

Байгаль орчны хохирол нь уламжлалт хувийн эрх зүйн хэм хэмжээг дангаар нь хэрэглээд шийдэх боломжгүй хэмжээний нийтийн эрхийн шинжтэй асуудал бөгөөд Монгол Улсын хувьд шүүхийн процесс, нэхэмжлэгчийн эрх, материаллаг эрх зүйн хүрээнд уян хатан хосолмол загвар нэвтрүүлэх бодит хэрэгцээ шаардлагатай үүссэн гэж үзэж байна.

ТББ-ын нэхэмжлэх эрхийг бодитоор хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд нийтийн эрхийн нэхэмжлэлийн хязгаартай загварыг нэвтрүүлж, “байгаль орчны эрх”-ийг Иргэний хуулийн хамгаалалтын хүрээнд багтаан тайлбарлах нь Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн экологийн эрхийг бодитойгоор хамгаалах үр нөлөөтэй алхам болох юм.

4. Дүгнэлт

Үндсэн эрх, эрх чөлөө нь Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны тулгуур хэсэг бөгөөд Үндсэн хуульд ёсны үр нөлөөг дээшлүүлэх, ардчиллын чанарыг тодорхойлох суурь үзүүлэлт юм.

Тиймдээ ч ОХУ, ХБНГУ, Австри зэрэг Үндсэн хуульд төртэй, Үндсэн хуулийн шүүхтэй улс орнууд Үндсэн хуулиараа баталгаажуулсан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахыг нэн тэргүүний зорилгоо болгож Үндсэн хууль болон Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульдаа энэхүү эрхтэй холбоотой маргааныг Үндсэн хуулийн шүүх нь

шийдвэрлэхээр тодорхой заасан байна. Харин манай улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд иргэн үндсэн эрх нь зөрчигдсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандах хамгаалалтын механизм тодорхой бус байна.

Цаашид төрийн эрх мэдлийн хуваарилалт, түүний шилжилт, Үндсэн хуулийн үнэт зүйл, Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил, Үндсэн хуульд ёсны доройтол, Үндсэн хуулийн хямрал, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэгт анхаарах замаар Монгол Улсын Үндсэн хуулийг орчин үеийн Үндсэн хуульд ёсны модель загварт нийцүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

Дээрх судалгаанд үндэслэн Монгол улсын Үндсэн хуульд ёсны хөгжилд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Иргэн өөрийн үндсэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргах эрхтэй” гэж нарийвчлан тусгах;

2. Монгол Улсад Үндсэн хуулийн зарчмын хэрэгжилтэд хяналт тавьдаг институт байхгүй тул Үндсэн хуулийн бодит хэрэгжилтийг үнэлэх, зөрчлийг илрүүлэх байнгын мониторингийн тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл УИХ-ын дэргэд Үндсэн хуулийн хэрэгжилтийн дэд хороо байгуулж, хууль, бодлого Үндсэн хуультай нийцэж буй эсэхэд хяналт тавих зэрэг хэлбэрийг хуульчлах нь зүйтэй. Ийнхүү байнгын мониторингийн тогтолцоо бүрдвэл Үндсэн хуулийн зарчим, үнэт зүйлсийн хэрэгжилтэд ил тод, тогтмол хяналт тавигдаж, төрийн хариуцлага болон хүний эрхийн хамгаалалт бодитоор дээшлэх болно.

3. Үндсэн хуульд заасан нэмэлт, өөрчлөлт хийх хүрээнд хүний эрхийн хамгаалалт, баталгааг төрийн бодлогоос дээгүүр үнэт зүйл хэмээн үзэж, аливаа нэмэлт, өөрчлөлт нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан, хамгаалсан чиглэлтэй байх эрх зүйн соёл төлөвшүүлэх шаардлагатай. Үүний тулд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийх процессыг ил тод, олон нийтийн оролцоотой явуулж боловсронгуй болгох нь зүйтэй.

4. Үндсэн хуульд ёсны баталгааг хангах хамгийн чухал хүчин зүйл бол иргэн бүрийн Үндсэн хуулийн мэдлэг, ойлголт, итгэл үнэмшил юм. Тиймээс Үндсэн хуулийн эрх зүйн боловсролыг ерөнхий болон дээд боловсролын хөтөлбөрт системтэйгээр тусгах, хууль зүйн сургуулиудын судалгааны чиглэлд Үндсэн хуулийн хэрэгжилтийн практик судалгааг түлхүү дэмжих, төрийн албан хаагчдын мэргэшлийн сургалтад Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэгийг заавал багтаах бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй.

5. Жил бүр Үндсэн хуулийн хэрэгжилтийн тайлан боловсруулж, олон нийтэд танилцуулан ил тод байдлыг хангах (Жишээ нь: “Үндсэн хуулийн хэрэгжилтийн индекс”, “Үндсэн эрхийн хэрэгжилтийн үнэлгээ” гэх мэт үзүүлэлтүүдийг бий болгох);

## 5. Эх сурвалж

- Г.Амаржаргалан, Байгаль орчинд учирсан гэм хорыг арилгах зохицуулалт дахь хувийн эрх зүйн онолын тулгамдсан асуудал. Хүрээлэн буй орчин ба хүний эрх: Харьцуулсан судлал” ОУЭШХ эмхтгэл, 1, 2023, х.38-44.

- *Eco Jurisprudence Tracker. (n.d.). Germany court case: seals in the North Sea (1988). Retrieved November 19, 2025, from Eco Jurisprudence Monitor: [https://ecojurisprudence.org/initiatives/germany-court-case-on-behalf-of-seals-in-the-north-sea-1988/?utm\\_source=chatgpt.com](https://ecojurisprudence.org/initiatives/germany-court-case-on-behalf-of-seals-in-the-north-sea-1988/?utm_source=chatgpt.com)*
- *Environmental Law Alliance Worldwide. (n.d.). European Commission v. Federal Republic of Germany (C-142/16) (European Court of Justice, Second Chamber) (26 April 2017). Retrieved from European Commission v. Federal Republic of Germany (C-142/16) (European Court of Justice, Second Chamber) (26 April 2017).*
- *Goethe-Institut. (n.d.). The History of the German Forest. Retrieved from The History of the German Forest.*
- *Pollock, F. (1895). The Law of Torts (6th ed.). London: Stevens & Sons.*
- *Poste, E., & Whittuck, E. A. (1904). Gai Institutiones. Oxford: Clarendon press.*
- *Zimmermann. (1996). The Law of Obligations: Roman Foundations of the Civilian Tradition. Oxford: Oxford University Press.*

---oOo---